

**ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ-ийн ЦАГ АГААРЫН МЭДЭЭЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭ
ХАРИУЦСАН ТЕХНОЛОГИЧ ИНЖЕНЕР**

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтын боловсруулсан үндэслэл:

- Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан
- Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

**Холбогдох хууль тогтоомжийн нэр,
огноо:**

Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21
өдрийн 240 дүгээр тогтоол

Дагаж мөрдөх огноо:

2024-10-01

**Албан тушаалын тодорхойлолтыг баталсан
огноо:**

Байгууллагын нэр:

Хэнтий аймгийн Ус, цаг уур, орчны
шинжилгээний төв

Нэгжийн нэр:

Мэдээлэл үйлчилгээний хэлтэс

Албан тушаалын нэр:

Цаг агаарын мэдээлэл, үйлчилгээ
хариуцсан технологич инженер

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Төрийн үйлчилгээний мэргэжил
ангилал, ТҮМ-6

Ажлын цаг:

Өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны

Хэнтий аймгийн Хэрлэн сумын 2-р баг
Тэмүүжингийн гудамж Н-13

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Онцгой нөхцлийн үед илүү цагаар
болон баяр амралт, шөнийн цагаар
ажиллана.

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Цаг агаарын бүх төрлийн урьдчилсан мэдээ, мэдээллийг хэрэглэгчдэд хүргэх, аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй салбаруудыг тусгай хэрэгцээний мэдээллээр хангах ажлын удирдан зохион байгуулна.

Албан тушаалын зорилт:

1. Цаг агаарын мэдээ, мэдээллээр үйлчлэх ажлын хөтөлбөр, удирдамж, хууль эрхийн акт, тогтоол, тушаал, гарын авлага, дүрэм, журам, гэрээ, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах
2. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй салбар, үйлчилгээг цаг агаарын тусгай хэрэгцээний мэдээллээр хангах ажлын удирдан зохион байгуулах
3. Ус, цаг уур, орчны бүх төрлийн мэдээ мэдээллийг нэр төрлөөр нь тогтоосон хугацаанд чанартай зохиож, хэрэглэгчдийг мэдээллээр хангах, байгаль цаг уурын гаралтай гамшигт үзэгдлээс сэрэмжлүүлэх
4. Цаг агаарын урьдчилсан мэдээний таарц, ончийг сайжруулах, гамшигт үзэгдлийн талаарх судалгаа хийж, дүгнэлт гаргах
5. Тусгай хэрэгцээний мэдээллээр үйлчлэх ажлын хүрээнд инженер, мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадвар, мэргэшлийн чадамж, туршлагыг дээшлүүлэх
6. Байгууллагын болон хэлтсийн үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн явуулахад үүрэг гүйцэтгэх

Албан тушаалын зорилтууд	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дугаар зорилтын хүрээнд:	Дэлхийн цаг уурын байгууллага /ДЦУБ/-ын зөвлөмж, Монгол улсын ус, цаг уур орчны мэдээлэл үйлчилгээний ажлын хөтөлбөрийн биелэлтийг хангах, гүйцэтгэлийг нэгтгэн үнэлэх	Хэрэгжилт, хувиар	Г, Т,
	Засаг даргын мөрийн хөтөлбөр, аймгийн урт болон дунд хугацааны хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд тусгагдсан ажил үүргийн биелэлтийг хангах	Хэрэгжилт, хувиар	Г,Т,Ш
	Мэдээлэл үйлчилгээний ажлын талаар бусад байгууллага, хувь хүмүүсээс тавьсан санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авч шуурхай барагдуулах	Гомдол, саналыг бүрэн барагдуулсан байх	Г, Ш

	Онцгой үед ажиллах төлөвлөгөө журмын хэрэгжилтийг хангах, хяналт тавих	Төлөвлөгөөний биелэлт -100%	Г,Х,Т,Ш
2 дүгээр зорилтын хүрээнд:	Аймгийн нутаг дэвсгэрт үйлдэгдэж буй агаарын хөлөгт үйлчлэх цаг агаарын бүх төрлийн мэдээний хангалт, чанарт хяналт тавих	Нислэгийн цаг уурын үйлчилгээний чанар ” Хангалттай” үнэлгээнд байх	Г,Х,Ш,Т
	Иргэний нисэхийн хууль дүрэм, ОУИНБ болон ДЦУБ-н зөвлөмж, шаардлага, технологийн мөрдөлтийг хангах, хянах	Үл тохирол, саатал, зөрчил гаргаагүй байх	Г,Х,Т,Ш
	Нисэхийн цаг уурын салбарын хамаарал бүхий баримт бичиг, гэрээ болон бусад хууль тогтоомжуудын биелэлтийг хангах	Биелэлт хувиар	Г,Х,Ш,Т
	Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг аэросиноптик нөхцөлөөр хангах ажлыг удирдах, зохион байгуулах	Амжилтгүй гаралтын тоо буурсан байх	Г, Х,Ш
	Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааны тайлан, судалгаа, дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах, гүйцэтгэх	Тайланг хугацаанд хийсэн байх	Г, Х,Ш
	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг тусгай хэрэгцээний мэдээллээр хангах /урьдчилсан, бодит/	Мэдээлээр бүрэн хангасан байх	Г,Х,Ш,Т
	Тусгай хэрэгцээний мэдээгээр үйлчлэх хүрээг өргөжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах	Хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлсэн байх	Г,Х,Ш,Т
Орон нутгийн удирдлагууд, аймгийн онцгой комиссын гишүүд, ОБГ, ХХААГ-ын удирдлагуудыг үнэн зөв мэдээллээр тухай бүр шуурхай хангах	Мэдээллээр тасалдалгүй хангасан байх	Г,Ш	
Цаг агаарын урьдчилсан, сэрэмжлүүлэх, сэргийлэх мэдээг олон нийтийн хэвлэл,мэдээллийн хэрэгсэл, техник, технологийн шийдэл ашиглан хэрэглэгчдэд өдөр бүр үйлчлэх	Сум багын түвшинд хүргэж ажиллах	Г,Х,Т,Ш	

3 дугаар зорилтын хүрээнд:	Цаг агаарын бүх төрлийн мэдээллээр удирдлага, мэргэжлийн байгууллагуудыг хангах, мэргэжил аргагүйн туслалцаа үзүүлэх	Хариу арга хэмжээ авч болохуйц хугацааны өмнө мэдээллийг хүргэсэн байх	Г,Х,Ш,Т
	Цаг агаарын бүх төрлийн урьдчилсан, сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээг үнэн зөв үнэлж нэр төрлөөр тогтсон хугацаанд нь гаргах	Мэдээний таарц улсын дундаж хувиас дээгүүр үнэлгээтэй байна.	Г,Т
	Цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээг зохиох	Мэдээний онч, таарц улсын дундаж түвшингээс дээгүүр байна.	Г, Т
	Цаг агаарын урт хугацааны буюу сар, улирлын төлвийг нарийвчлан зохиох	Мэдээг тогтоосон цаг хугацаанд зохиосон байх	Г, Т
4 дугаар зорилтын хүрээнд:	Байгаль, цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдлийн хохирлын мэдээг ОБГ-тай хамтран гаргаж мэдээлэх	Хохирлыг мэдээг үнэн зөв Тодорхойлох нөхцлийг бүрдүүлсэн байх	Г,Х,Ш
	Цаг агаарын урьдчилсан мэдээний таарц, ончийг дүгнэх, судалгаа хийх	Таарц, ончийг өдөр бүр дүгнэсэн байх	Г,Х,Ш,Т
	Бүс нутгийн уур амьсгалын нөхцлийг тодорхойлох, гамшигт үзэгдлийн талаар судалгаа, дүгнэлт гаргах	Жил бүр хийгдсэн байх	Г,Х,Ш,Т
	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил гүйцэтгэх, удирдан зохион байгуулах	Жил бүр 1-ээс доошгүй сэдвээр хийсэн байх	Г,Х,Ш,Т
5 дугаар зорилтын хүрээнд:	Нисэхийн үйлчилгээ үзүүлэх эрх сунгах, олгох сургалтуудад инженерүүдийг хамруулах, батламжлуулах	Эрх авч сургалтанд хамрагдсан байх	Г,Х,Ш,Т
	Улсын сүлжээний салбаруудыг цаг уурын бүтээгдэхүүн үйлчилгээ, мэдээллээр хангах сургалт, дадлагыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэх	Сургалт зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн байх	Г,Х,Ш,Т
	Цаг уурын мэдээлэл үйлчилгээ, мэдээлэл, дамжуулах, хүлээн авах ажилд үр өгөөжтэй шинэ техник, технологийг ашиглах, нэвтрүүлэх	ЦУ-ын үйлчилгээний үр өгөөж дээшилсэн байх	Г,Х,Ш,Т

	Цаг уур, орчны шинжилгээний газар болон бусад газраас зохион байгуулах сургалт, семинарт инженер, техникчдийг хамруулах	Бүрэн хамруулсан байх	Г,Х,Ш,Т
	Цаг агаарын урьдчилсан мэдээ гаргах аргуудыг хэрэглэх, турших	Мэдээний таарцыг сайжруулсан байх	Г,Х,Ш,Т
	Таараагүй мэдээнд задлан шинжилгээ хийж, алдаанаасаа суралцах	Таараагүй мэдээний тоо буурсан байх	Г,Х,Ш,Т
6 дугаар зорилтын хүрээнд	Дээд байгууллага, удирдлагын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж тайлагнах	Үүрэг даалгаврын биелэлт, хувиар	Г,Х,Ш
	Хэлтсийн даргатай гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж биелэлтийг хангаж ажиллах	Биелэлтийн үнэлгээ "сайн"-аас дээш байх	Г,Ш,Х
	Хэлтсийн даргын үүрэгт ажлыг орлох, үүрэг гүйцэтгэх	Шаардлагатай үед шууд орон ажилласан байх	Г,Ш
	Нисэхийн цаг уурын үйлчилгээний инженерийн хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн асуудалд анхаарч ажиллах	Ажиллах нөхцөл сайжирсан байх	Г, Х,Ш,Т
	Төрийн албан хаагчийн ёсзүй, үйлчилгээний стандартыг мөрдөн ажиллах	Гүйцэтгэл хувиар	Г
	Байгууллага, хамт олны саналаар зөвлөл, ажлын хэсэгт сонгогдон ажиллах	Зөвлөл, ажлын хэсгийг удирдах болон оролцон ажилласан байх	Г, Х,Ш

III. АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА

Боловсрол	Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх	
Мэргэжил	Цаг уурын инженер D0664 Цаг уурын мэдээлэл,прогноз D0666	
Мэргэшил	Урьдчилан мэдээлэх инженерээр мэргэшсэн байх	
Туршлага	Цаг уурын инженер, урьдчилан мэдээлэхийн инженерээр 3-аас доошгүй жил ажилласан байх	
Ур чадвар	Удирдан зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> Байгууллагын болон нэгжийн үйл ажиллагааг зохион байгуулж гүйцэтгэлийг үнэлэх Байгууллагын эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх

	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> Судалгааны дүнд тулгуурлан салбарын хөгжлийн зорилтыг тодорхойлох Тоон мэдээлэлтэй ажиллах, нэгтгэн дүгнэх
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> Хуульд нийцсэн шийдвэр гаргах Шийдвэрийн төслийн шууд ба шууд бус үр дагаврыг үнэлж шийдвэрийн хувилбарын талаар зөвлөх
	Манлайлах	<ul style="list-style-type: none"> Ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах Ёс зүйгээр бусдыг манлайлан үлгэр дууриал үзүүлэх
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> Албан хаагчдын санал бодлыг сонсож, бүтээлч санаачилга, зөв хандлагыг дэмжих Албан хаагч бүртэй тэгш хүртээмжтэй харилцах, ажиллах
	Бусад	<ul style="list-style-type: none"> Албан хэрэг хөтлөх, боловсруулах чадвартай байх Компьютерийн өргөн хэрэглээний болон салбарын үйл ажиллагаанд ашиглагддаг программ, технологиудыг ашигладаг байх Англи хэл эсвэл бусад гадаад хэлнээс мэргэжлийн дагуух эх сурвалж, мэдээллийг ашигладаг байх

IV. АЛБАН ТУШААЛЫН ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: УЦУОШТөвийн дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: <ol style="list-style-type: none"> Нислэгийн үйлчилгээ: <ul style="list-style-type: none"> Нисэхийн үйлчилгээний инженер - 1 Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйлчилгээ: <ul style="list-style-type: none"> ЦАЗНЭ-ийн мэргэжилтэн -1 Урьдчилан мэдээлэх <ul style="list-style-type: none"> Ээлжийн синоптик инженер-4 Орон нутгийн салбар: <ul style="list-style-type: none"> Өртөө хариуцсан инженер -8 Цаг уурын техникч -42 <p style="text-align: center;">Нийт -56</p>	Бусад харилцах субъект: <p><i>Байгууллагын дотор:</i></p> <ul style="list-style-type: none"> Дарга Мэдээлэл Үйлчилгээний хэлтсийн дарга ЦАЗНЭ-ийн үйлчилгээ хариуцсан ахлах мэргэжилтэн Инженер техникчид, бусад ажиллагсад <p><i>Шууд харилцах байгууллага:</i></p> <ul style="list-style-type: none"> ЦУОШГ, УЦУОСМХ, НЦУТ, Аймаг, сумын ИТХ, ОБГ, ЗД, ЗДТГ, байгууллага, аж ахуйн нэгж, ард иргэд Өртөө, харуулын техникч, ажиглагч нар

V. АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

<p>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</p>	<p>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</p>
<p>Албан тушаалын нэр: Мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга /Т.Нарангэрэл/ (гарын үсэг) (Эцэг, эхийн нэрийн эхний үсэг, өөрийн нэр) 2024 оны 09 дүгээр сарын-ны өдөр</p>	<p><u>Байгууллагын нэр:</u></p> <p><u>Шийдвэрийн огноо:</u></p> <p><u>Дугаар:</u></p>
<p>Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:</p>	
<p><u>Байгууллагын нэр:</u> ХЭНТИЙ АЙМГИЙН УЦУОШТ</p> <p><u>Шийдвэрийн огноо:</u></p> <p><u>Дугаар:</u></p> <p>(тамга/тэмдэг)</p> <p>..... Б.ХЭРЛЭНЧИМЭГ (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 20... оны ... дугаар сарын ... -ны өдөр</p>	